

**ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БАЙГАА ЛГБТИ ХОРИГДОЛТОЙ АЖИЛЛАХ  
НИЙГМИЙН АЖЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙ**  
THEORETICAL AND METHODOLOGICAL WORK FOR LGBTI  
PRISONERS



**Г.БАТЖАРГАЛ**

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн багш, ахмад

**Товч агуулга:** Хорих ял эдлүүлэх ажиллагаанд шинэ тутамд үүсч буй олон асуудлуудын нэг лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс (ЛГБТИ) хоригдлын ялгаатай байдал юм. ЛГБТИ хоригдлуудад хууль эрх зүй, орчны, мөн хүйсийн ялгааны улмаас үүдэн сэтгэл зүй, эрүүл мэнд, бие физиологын болон ахуй хэрэглээний хүндрэл бэршээлүүд тулгардаг. ЛГБТИ хоригдолтой ажиллах нийгмийн ажлын онол, арга зүй нь нийгмийн ажилтан ЛГБТИ хоригдолд мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадварыг нэмэгдүүлэх, цаашлаад олон нийтийн дунд үнэн зөв ойлголт өгөх ач холбогдолтой.

**Түлхүүр үг:** ЛГБТИ, ялгаатай байдал, бэлгийн чиг баримжаа, хандлага, мэдлэг, ур чадвар, хоригдол, нийгмийн ажилтан, нийгмийн ажлын үйлчилгээ

**Abstract:** The difference between a lesbian, gay, bisexual, transgender and intercourse (LGBTI) prisoner is one of the many emerging issues in the imprisonment. The LGBT prisoners face psychological, health, physical and environmental problems as a result of legal, environmental, and gender discrimination. The theoretical and methodological approaches to work with LGBTI prisoners is to increase the ability of the social worker to provide specialized services to LGBTI prisoners and to provide a better understanding among the public.

**Key word:** LGBTI /лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс/, differences, sexual orientation, attendance, knowledge, skills, prisoner, social worker, social work services

Бэлгийн чиг баримжааны тухай ойлголт: Бэлгийн чиг баримжаа гэдэг нь бие махбод, хайр дурлал, зүрх сэтгэлийн хувьд аль нэг, эсвэл аль аль хүйсийн хүмүүст татагдах төрөлхийн үзэгдлийг хэлнэ. Бэлгийн чиг баримжаа нь төрөлхийн ба өөрчлөгдөшгүй байдаг. /Жогжакартын зарчмууд 2010/ Хүний бэлгийн чиг баримжааг төрөлхийн ба олон талт мөн чанар хэмээн хүлээн зөвшөөрч Америкийн сэтгэц, эмгэг судлалын холбоо 1973 онд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өвчний ангилалаас албан ёсоор хасаж, үүний дараа 1974 онд Америкийн сэтгэл судлалын холбоо ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хүний төрөлхийн ба салгаж болшгүй мөн чанар хэмээн үзэж сэтгэцийн өвчин биш гэдгийг мөн зарлажээ.

Харин олон улсын түвшинд 1990 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хүний төрөлхийн ба салгаж болшгүй мөн чанар хэмээн хүлээн зөвшөөрч сэтгэцийн өвчнөөс албан ёсоор хассанаа зарласан байна. Үүнээс өмнө 1948 онд ДЭМБ-аас олон улсын өчний 6 дугаар ангилалыг хэвлүүлсэн ба энэ нь сэтгэцийн өвчний жагсаалт бүхий анхны ангилал байсан юм. Хэдийгээр энэхүү 6 дугаар ангилалд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хувь хүний хөгжилтэй холбоотой бэлгийн гажуудал хэмээн ангилсан боловч маш олон судалгаагаар энэ нь батлагдаагүй байна. Мөн олон судалгаагаар ижил хүйсийн зан үйл нь хүний бэлгийн мөн чанарын маш өргөн тохиолдох нэг хэлбэр ба илэрхийлэл гэдэг нь нотлогджээ. Өнгөрсөн 50 жилийн дотор өвчнийг ангилах олон тогтолцооноос ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг гаргаж дууссан. Энэхүү өөрчлөлт нь хүний эрхийн хэм хэмжээ болон бэлгийн чиг баримжааны илэрхийллийг эмгэгжүүлэх анагаахын үүднээс үзэх эмпирик нотолгоо байхгүйтэй холбоотой байна.

Бэлгийн чиг баримжаа хэрхэн, яагаад бүрэлддэгийг шинжлэх ухаан одоо ч бүрэн тогтоогоогүй ч ген, ургийн хөгжилд эхийн хэвлий дэх дааврын нөлөө, удамшил гэх мэт маш олон хүчин зүйлээс үүддэг гэж үздэг.

Шинжлэх ухаан хүний бэлгийн чиг баримжааг ерөнхийд нь 3 ангилж үздэг ба үүнд эсрэг хүйсийн (heterosexual), ижил хүйсийн (homosexual), аль аль хүйст чиглэсэн (bisexual) бэлгийн чиг баримжаа багтдаг.

Мөн шинжлэх ухааны үүднээс шалтгаан ба явцыг нь тодорхойлж, чиглүүлэх огт боломжгүй, хүн бүрийн төрөлхийн, тухайн хүний салшгүй

мөн чанар гэж үзэн бэлгийн чиг баримжааг биологийн шинжлэх ухаануудын үүднээс авч үзэхээс илүү эрх зүйн шинжлэх ухааны үүднээс авч үзэх ёстой судлагдахуун буюу эрх хэмээн 1994 оноос хойш олон улсын эрх зүйд үзэх болсон. НҮБ-ын Иргэний болон улс төрийн олон улсын пактын хэрэгжилтийг хянадаг Хүний эрхийн хорооноос 1994 онд анх удаа “Хүйс” хэмээх ойлголтод хүйстэй холбоотой хүний хайр дурлал болон бэлгийн амьдралын илэрхийлэл болсон бэлгийн чиг баримжаа гэдэг ухагдахуун багтана хэмээн заасан байна.

ЛГБТИ гэдэг нь лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс гэсэн үгийн товчлол юм. ЛГБТИ хэмээх үг нь бүх бэлгийн цөөнхийг бүрэн төлөөлөх утгаараа зөв хэрэглээ болдог.<sup>1</sup>

Трансжендэр гэдэг нь өөрийн хүйсээ төрөхөд өгөгдсөн хүйснээсээ өөрөөр мэдэрч, тодорхойлж, илэрхийлдэг хүмүүсийг хамарсан нэгдсэн нэр томьёо юм. Трансжендэр хүмүүс хүйсээ өөрийгөө мэдэрч буй дотоод хүйсийнхээ мэдрэмжтэй нийцүүлэн илэрхийлдэг.

Интерсекс гэдэг нь эр эсвэл эм хүйсийн хэвшмэл ойлголтод багтдаггүй хүйсийн шинж тэмдэгтэй төрсөн хүнийг хэлдэг.

Бисексуал гэдэг нь ижил болон эсрэг аль ч хүйсийн хүнд сэтгэл, хайр дурлал бие махбод, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй зүрх сэтгэлийн дотно ба бэлгийн харилцаа үүсгэх гүн гүнзгий мөн чанар, чадвар буюу аль ч хүйсийн хүнд татагдах бэлгийн чиг баримжаа юм.

Жендэркүйр гэх ойлголт нь эрэгтэй, эмэгтэй гэх хүйсийн хоёр туйлд өөрсдийгөө багтааж үздэггүй, эсвэл өөрийгөө аль аль хүйсэнд хамааруулж мэдэрдэг хүмүүсийн хувьд хэрэглэдэг олон улсын нэр томьёо юм.

Бэлгийн цөөнх хүмүүстэй ажиллах, тусламж үзүүлэх асуудлаар үүсдэг үйлчилгээний чанар нийгмийн ажилтнуудын хандлага, мэдлэг ба ур чадвараас ихээхэн хамарна. ЛГБТИ хүмүүсийн онцлог асуудал бусад хүн амынхнаас үнэмлэхүй ялгаатай байдаггүй, анхаарах онцлогууд л байдаг тул нийгмийн ажилтнууд өдөр тутмынхаа үйл ажиллагаанд дагах, мөрдөх ёстой хэм хэмжээ ба загвар туршлагыг өөрсдийн ажлын хүрээнд үүсгэж байдаг.<sup>2</sup>

<sup>1</sup> <http://mminfo.mn>

<sup>2</sup> ЛГБТИ-Хүний эрх Алунгоо. Б, Анараа.Н., (2018) Улаанбаатар хот

*ЛГБТИ хоригдолтой ажиллахад шаардагдах нийгмийн ажилтны  
хандлага, мэдлэг, ур чадвар*

**Хандлага:** Хорих байгууллагын нийгмийн ажилтан бусдыг ялгаварлан гадуурхахгүйн тулд бэлгийн цөөнх хоригдолтой ажиллахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа нь хэвийн бөгөөд хүний салшгүй мөн чанар.
2. ЛГБТИ хоригдол өөрийгөө нээлттэй илэрхийлэх нь өөрийнхөө мөн чанарыг илэрхийлж байна гэсэн үг.
3. ЛГБТИ хоригдолд нийгмээс ирдэг эерэг ба сөрөг хандлагыг дүгнэх.
4. ЛГБТИ хоригдол нь ял эдлэх хугацаандаа бусдын физиологийн хэрэгцээг хангах үүднээс зохиомлоор ЛГБТИ болсон гэх буруу ойлголт
5. Нийгмийн ажилтан өөрийн үйлдэл, үг, биеийн өгүүлэмжийг ухамсрын, зан төлөвийн, үйл хөдлөлийн түвшинд анхаарах.
6. Хувьдаа болон мэргэжлийн түвшинд ЛГБТИ соёл ба хувь хүмүүсийг /хоригдлыг/ илүү ойлгох тал дээр ажиллах.

Өмнө нь ижил хүйсийн эсвэл бисексуал бэлгийн чиг баримжааг анагаахын үүднээс үндэслэлгүйгээр эмгэг хэмээн үзэх үеэс бүрэлдэн тогтсон ойлголт бол хүмүүс зөвхөн гетеросексуал байдаг ба энэ л ганц хэвийн бэлгийн чиг баримжаа хэмээн үздэг байсанд зарим нийгмийн ажилтан, сэтгэл зүйн мэргэжилтнүүд итгэсээр байдаг, ухамсаргүйгээр энэхүү итгэл үнэмшлээ өөрийн хандлагаар илэрхийлдэг. Тиймээс хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар аль болох шинжлэх ухааны мэдээлэл, судалгаанд үндэслэсэн мэргэжлийн ёс зүйгээсээ үл хазайн өөрийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд ялгаварлан гадуурхахгүй байх нь тун чухал юм. Жишээ нь:

- Гей хоригдлыг бэлгийн чиг баримжаатайгаа холбоотой ямарваа зүйл хэлэхэд ямар нэгэн байдлаар шууд болон шууд бус байдлаар дургүйцэх,
- Хэн нэгэн ЛГБТИ асуудлыг ярихад сэдвийг солих, үл ойшоох,
- Асуудлыг тайлбарлахдаа бэлгийн чиг баримжааг хэт чухал мэт, эсвэл ямар ч хамааралгүй мэт ярих,
- Тусалцаа авч буй хоригдол гей эсвэл лесбиян гэдгээ илэрхийлэхэд “Ийм үе байдаг”, “Бэлгийн чиг баримжаа чинь өөрчлөгдөнө” гэж хэлэх
- Бэлгийн цөөнх хоригдлыг чухал бус хүмүүс мэт ярих,

- Ямарваа мэргэжлийн дүгнэлт хийхдээ /зан байдал, сэтгэл зүйн тодорхойлолт гаргах гм/ тухайн хоригдлын зөвхөн бэлгийн чиг баримжааг үндэслэх,

- Хоригдлын бэлгийн чиг баримжааг сэтгэцийн эмгэг гэж үзэх,

**Мэдлэг:** Нийгмийн ажилтнууд ЛГБТИ хүмүүс өөрсдийгөө хэрхэн тодорхойлдогийг мэдэх, өөрсдийгөө тодорхойлдог үг хэллэгийг нь хэрэглэх ёстой. Фелин (1998) “Зөв үг хэллэгийг ашиглах нь гетернорматив (буюу зөвхөн эсрэг хүйсийн бэлгийн чиг баримжаа нь цор ганц байдаг, байх ёстой хэм хэмжээ гэж үзэх үзэл) хэвшмэл ойлголтыг даамжруулахгүй, мөн хэн нэгийг доромжлохгүй байх зорилготой” гэж тодорхойлсон байдаг.

ЛГБТИ хүмүүсийн дунд маш олон үг хэллэг байдаг ч хорих байгууллагын нийгмийн ажилтан нь тухайн хоригдлын хүслээр үг хэллэгийг ашиглах нь зүйтэй. Бэлгийн цөөнх хүмүүс өөрсдийгөө тодорхойлж байгаа байдал нь тэдний нас ба соёлын онцлогтой холбоотой байдаг. Жишээ нь ахимаг насны эмэгтэй хүн өөрийгөө “Гомосексуал” /энэ үгийг одоо үед огт хэрэглэдэггүй болохыг анхаарна уу, ялангуяа Монгол хэл дээр/ гэж хэлдэг бол залуу хүн өөрийгөө “Күийр” хэмээн хэлдэг байж болно. Зарим эмэгтэйчүүд өөрийгөө “Гей” гэж хэлдэг бол зарим нь энэ үгийг доромж үг гэж үздэг учир “Лесбиян” гэж дуудуулахыг хүсдэг.

ЛГБ хүмүүсийн бэлгийн чиг баримжаа гетеросексуал хүмүүстэй адил төрөлхийн учир бэлгийн чиг баримжаа гэдэг нэр томъёог ашиглах нь зөв. Ямар нэр томъёо ашиглахаа мэдэхгүй байгаа бол нийгмийн ажилтан тухайн хоригдлоос лавлах хэрэгтэй. Мөн нийгмийн ажилтнууд ЛГБТИ хүмүүсийн дотны хүний талаар ярихдаа нөхөр эсвэл эхнэр гэх үг ашигласнаас “Хамтрагч” гэдэг үгийг ашиглаж, ямар нэг хүйс заахгүйгээр ярьж занших нь зүйтэй. Ярихдаа хүйс заахгүйгээр ярих нь зөв бөгөөд энэхүү зарчмыг ямар нэгэн материал бөглүүлэх /нөхцөл байдлын үнэлгээ хийх/ эсвэл ашиглахдаа багтаасан байх шаардлагатай.

Дарамт, дээрэлхэлт ба хүчирхийлэл: ЛГБТИ хүмүүс нь өөрсдийг нь хүлээн зөвшөөрдөггүй, дэмждэггүй нийгэмд амьдарсаар ирсэн. Тухайлбал хууль тогтоомжийн хүрээнд эрх нь хамгаалагдаагүй, сурч боловсрох, олон нийтийн ойлголт гм. Мөн хорих байгууллагын нийгмийн ажилтан ЛГБТИ хүмүүс өдөр тутмынхаа амьдралд ямар нэгэн байдлаар байнга ялгаварлан гадуурхагддаг ба үүнээс үүдэн олон асуудал үүсдэгийг ойлгох хэрэгтэй.

Ялгаварлан гадуурхалтын хэлбэрүүд: ЛГБТИ хүмүүс хүчирхийлэлд өртсөн тухайгаа бусдад мэдэгддэггүй нь өөрийн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээсээ болоод давхар ялгаварлан гадуурхагдахаас айдагтай холбоотой юм.

**Ур чадвар:** ЛГБТИ хоригдлуудад ээлтэй орчин бүрдүүлэх: Хорих ангийн номын сан, нийгмийн ажилтны ажлын өрөө зэрэг газар ЛГБТИ хүмүүст зориулсан төрөл бүрийн гарын авлага, ном, сонинг нүдэнд ил газар тавих. Эдгээрийг ил тавьснаараа ЛГБТИ хүмүүст нээлттэй орчинг бүрдүүлж, тэдэнд бэлгийн чиг баримжааны тухай ярих боломжийг олгож байгаа гэсэн үг юм.

Дэлхийн 2 дугаар дайны үед ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүсийг Еврейчүүдийн нэгэн адил хоморголон устгасныг санах, дахин тийм зүйлийг давтуулахгүйн бэлэг тэмдэг болсон урвуугаа харсан ягаан гурвалжин дүрсийг өлгөх /байршуулах/, эсвэл дэлхий даяар ЛГБТИ хүмүүсийн бэлэг тэмдэг болсон “Солонго” тугийг тавьж, ЛГБТИ хоригдлын эрхийг дэмждэг гэдгийг үзүүлэх боломжтой.

Хоригдлын бэлгийн чиг баримжаанаас өөр асуудлаар тулгарсан бэрхшээлд туслалцаа үзүүлэх: Нийгмийн ажилтан аливаа хүнийг бэлгийн чиг баримжаа дээр суурилан дүгнэлт хийх бус харин тэр хүнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд нь туслахад оршино.

ЛГБТИ хоригдлын асуудлыг тэр хүний үүднээс харж үзэх: Жишээ нь ЛГБТИ хоригдол бэлгийн чиг баримжаанаасаа болон ямар нэг сөрөг нөхцөл байдалтай тулгарсан бол өөрөөсөө ичих ба өөртөө гутрах улмаар сэтгэл гутрал, сандрах сэтгэцийн өвчинд хүргэх магадлалтай байдаг.

Хувь хүнд илэрч болзошгүй гомофобийг олж харах: Зарим ЛГБТИ хүмүүс бэлгийн чиг баримжаандаа эргэлздэг өөрөө гомофоби үзэлтэй байж болзошгүй юм. Энэ нь нийгмийн ажилтнаас тусламж хүсэхэд өөрсдөд нь саад болдог. Гомофоби үзлээ тухайн ЛГБ хоригдол өөрөө анзаарахгүй эсвэл мэдэхгүй байх боломжтой. Энэ байдлыг олж харахын тулд нийгмийн ажилтан хоригдлын ярьсан зүйлийг анхааралтай сонсох хэрэгтэй.

Шаардлагатай тохиолдолд тусламж авч буй хүний ойр дотны хүнтэй уулзаж ярилцах: ЛГБТИ хоригдол маш олон төрлийн стресс дарамтад өртдөг ба үүнийг давах туулахад тухайн хүний гэр бүл, дотны хамтрагч чухал үүрэгтэй. Хууль, эрх зүйн үүднээс гэр бүлийг нь хүлээн зөвшөөрөөгүй, эрүүл мэнд, сэтгэл зүйн гэх мэт олон төрлийн хүчин зүйлс

хувь хүмүүсийн харилцаанд болон нийгмийн харилцаанд нөлөөлж байдаг. Иймд нийгмийн ажилтнууд тэдгээрийн харилцаанд байгаа хосуудын ялгаатай байдал, сул тал, давуу тал ба харилцан хамааралтай байдлыг ойлгох хэрэгтэй.<sup>3</sup>

ЛГБТИ хоригдолтой харилцахдаа нийгмийн ажилтан хувь хүний ялгаатай байдалд халдсан ёс зүйгүй үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй.

Нийгмийн ажилтан та хувь хүнийхээ хувьд ЛГБТИ хоригдлуудад шүүмжлэлтэй талаас ханддаг бол үйлчилгээний үр дүнд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Иймд та өөрийн мэдлэгээ нэмэгдүүлэх чин хүсэлтэй байх нь чухал юм.

*ЛГБТИ хоригдолтой ажиллах нийгмийн ажлын үйлчилгээний үе шатуудад анхаарах асуудлууд*

ЛГБТИ хоригдолтой ажиллах нь соёлын ялгаатай хоригдолтой ажиллахтай төстэй. Тэд ялгаатай байдлаасаа болж сэтгэцийн эрүүл мэндэд нөлөө үзүүлэхүйц өдөр тутмын ялгаварлан гадуурхалт, стресс дарамттай байнга нүүр тулж байдаг.

**Харилцаа холбоо тогтоох үе шат:** Харилцаа холбоо тогтоохдоо аль болох тэдэнд нээлттэй чөлөөтэй харилцах боломж бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Анхны уулзалтын өмнө ЛГБТИ хоригдлын онцлог шинж, ялгаатай байдлуудын талаар судалж, ойлгож мэдсэн байх шаардлагатай. Энэ нь ЛГБТИ талаарх хэвшмэл тогтсон буруу ойлголтоос салахад туслах болно. Харилцан итгэлцэл бүхий харилцаа холбоог бий болгож хөгжүүлэх хэрэгтэй. ЛГБТИ хоригдол ялгаварлан гадуурхал, үгүйсгэл, үйлчилгээний нууцлалын талаар итгэлгүй байгаа байдлаас шалтгаалан хувийн мэдээллээ өгөхөөс зайлсхийх магадлалтай байдаг. Хоригдол тантай чөлөөтэй ярьдаг болох хүртэл тодорхой цаг хугацаа зарцуулж болно. Иймд түүнийг яаруулах, ярилцахыг тулгаж болохгүй ба хүлээцтэй хандах хэрэгтэй.

Нууцлал: Анхны уулзалтын үеэр хоригдлын нууцлалын талаарх холбогдох журмыг танилцуулна. Ямар ч тохиолдолд нууцлалыг хадгалахыг эрмэлзэх бөгөөд нууцыг задруулах дараах тохиолдлууд байж болдог бөгөөд энэ тохиолдолд түүний нууцлалыг задруулах талаар түүнд урьдчилан сануулах хэрэгтэй. Үүнд:

- Хоригдол өөрийгөө гэмтээх буюу амиа егүүтгэх магадлалтай бол,

<sup>3</sup> ЛГБТИ-Хүний эрх Алунгоо, Б, Анараа.Н., (2018) Улаанбаатар хот

- Хоригдол бусдыг гэмтээх буюу бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахыг завдаж буй бол,

- Хоригдол хэн нэгний хүчирхийлэл дарамтад өртөж буй талаар мэдээлэл өгсөн бол тухайн хоригдлыг хамгаалах зорилгоор нууцлалыг задруулж болдог.

- Хоригдлын эрүүл мэндийн асуудлаар эмнэлгийн ажилтанд мэдээлэл өгөх шаардлага гарсан тохиолдолд.

Харилцааны ур чадвар:

Нийгмийн ажилтан ЛГБТИ хоригдол болон тэдний гэр бүлтэй ажиллахдаа харилцааны ур чадвартаа анхаарал хандуулах хэрэгтэй. Хоригдолд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хамгийн чухал ур чадваруудын нэг нь харилцааны ур чадвар юм.

Идэвхтэй сонсох чадвар: ABC зарчимд тулгуурлан хэрэгждэг

<p><b>A Affirming буюу баталгаажуулах</b></p> <p>Хоригдол ихэвчлэн өөрийн бусадтай хуваалцах дургүй мэдээллээ танд ярьж байдаг. Тэдний ярьж буй зүйлсийг хүлээн зөвшөөрөх, харну өгөх замаар харилцааг дэмжиж буй илэрхийлэх хэрэгтэй. Тухайлбал: “Ярих хэцүү байсан байх аа. Өөрийн талаар ярилцсанд баярлалаа” зэргээр дэмжиж болно.</p>	<p><b>B Being sensitive буюу мэдрэмжтэй байх</b></p> <p>Харилцааны үед хоригдлын цаашид нээлттэй ярилцах явцад дэмжлэг үзүүлэхийн тулд нээлттэй харилцааг дэмжих хэрэгтэй. Тухайлбал “Танд ямар хэцүү байсныг ойлгож байна, дахин ийм зүйл болохгүй байх” зэргээр ярилцах хэрэгтэй.</p>	<p><b>C Clarifying буюу тодруулж асуух</b></p> <p>Шаардлагатай тохиолдолд хоригдлын ярьж буй зүйлийг дэлгэрүүлэн асууж болно. “Үүнийг дэлгэрүүлэн ярьж өгнө үү, хэзээ энэ зүйл тохиолдсон бэ” гэх мэт</p>
--	---	---

**Нөхцөл байдлын үнэлгээ хийх үе шат:**

Нөхцөл байдлын үнэлгээ нь хоригдолд тулгарч буй асуудал бэрхшээлүүдийн талаар үнэлгээ хийж тодорхойлдог. Нийгмийн ажилтан нийт хоригдлуудаас авдаг нөхцөл байдлын үнэлгээний олон аргуудаар ЛГБТИ хоригдлын нөхцөл байдлыг үнэлж болно. Түүнээс гадна дараах хэлбэрээр нөхцөл байдлыг үнэлнэ.

№	Тулгарч болох асуудлууд	Илэрхийлэх хэлбэр
1	Айдас түгшүүр	<ul style="list-style-type: none"> <li>- Үл хүлээн зөвшөөрөх</li> <li>- Хүчирхийлэл ба дарамт</li> <li>- Ялгаварлан дагуурхал, алагчлал</li> <li>- Гэр бүлээсээ тусгаарлагдах</li> <li>- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал үүсэх</li> </ul>
2	Өөрийгөө илэрхийлэх байдал	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх</li> <li>- Гэр бүл, найз, бусад хоригдлын дунд өөрийнхөөрөө чөлөөтэй байх</li> <li>- Бусдын адил хүн гэдгээ мэдрэх</li> <li>- Өөрийнхөөрөө байх нь асуудал биш гэдгийг мэдрэх</li> </ul>
3	Өөрийгөө илэрхийлэхэд тулгарч болох мэдрэмжүүд	<ul style="list-style-type: none"> <li>- Айдас түгшүүр, эмзэг байдал</li> <li>- Тайвшрал</li> <li>- Хэн гэдгээрээ бахархах</li> <li>- Тодорхой бус байдал</li> <li>- Мэдрэмтгий байх</li> </ul>
4	Бусад хүмүүсийн сэтгэгдэл	<ul style="list-style-type: none"> <li>- Айх, эвгүйцэх, тухгүй байх</li> <li>- Юу хэлэх, юу хийхээ мэдэхгүй байх</li> <li>- Уурлах, бухимдах, зэвүүцэх</li> <li>- Дэмжих</li> <li>- Хүндэтгэх</li> </ul>
5	Бусдаас хүсч буй нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> <li>- Байгаагаар нь хүлээн авах</li> <li>- Дэмжих</li> <li>- Ойлгох</li> <li>- Тайтгаруулах, тайвшруулах</li> <li>- Илүү ойр дотно харилцах</li> <li>- Сөрөг хандлага гархагүй байх</li> </ul>

**Үйлчилгээг хүргэх үе шат:**

ЛГБТИ хоригдолд бэлгийн чиг баримжаа илэрхийлэлд тулгарсан асуудлуудаас гадна бусад хоригдлуудад тулгарч байдаг гэр бүл, нийгэм, сэтгэл зүй, эдийн засаг, хууль эрх зүйн гэх мэт асуудал бэрхшээлүүд ч бас тулгардаг. Гиймээс хоригдлын асуудал, хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тодорхойлсны үндсэн дээр үйлчилгээг төлөвлөх хэрэгтэй.


ЛГБТИ хоригдолд дараах асуудлууд тулгарсан байж болох юм. Үүнд:

- Гэр бүл, найз нөхөд, шашин шүтлэг, ажил сургуулийн орчноос тусгаарлагдсан,

- Ялгаварлал, алагчлал, үзэн ядалтаас үүдэлтэй зөрчлүүд
- Хүчирхийлэлд өртсөн
- Сэтгэцийн хямрал, амиа хорлох талаарх бодлууд
- Хорт зуршил хэрэглэх
- Өөрийгөө үнэлэх үнэлэмж буурах
- Бусад хоригдлын зүгээс дарамт шахалт үзүүлэх, эсвэл нэр хоч өгч шоолж тохуурхах.

- Хорих байгууллагын алба хаагдчын харилцаа хандлага, үл ойлголцол

Хямралын үеийн үйлчилгээний зорилго нь хоригдолд хүрээлэн буй орчноос үүдсэн хямралын асуудлыг шийдэж, даван туулах чадварыг сэргээхэд чиглэгдэнэ. Хямрал гэдэг нь гэнэтийн нөхцөл байдлын өөрчлөлтийн улмаас зан байдлаа хянах чадвараа түр алдах, өөрийгөө хянах, өөртөө дэмжлэг үзүүлэх эх үүсвэрүүд нь сул болох нөхцөл байдлыг хэлдэг.



Дэмжих үйлчилгээ нь хүнд нөхцөл байдлыг даван туулахад нь хоригдлыг хөгжүүлэх замаар туслах явдал юм. Жудиф Нелсон дэмжих үйлчилгээг тодорхойлохдоо хүнд илүү аятайхан, таатай, зоригтой итгэлтэй байхад нь туслах арга хэмжээ юм гэж тодорхойлсон. Тэрээр мөн 4 төрлийн дэмжих хэлбэр байдгийг тодорхойлсон. Үүнд:



Зөвлөгөө өгөх: Биеийн хэлэмж-таны хэлж буй үгнээс илүү ихийг ярьдаг.

- Харцаар холбоо тогтоох
- Гарын хөдөлгөөн
- Дуу хоолойн өнгө
- Биеийн хөдөлгөөн
- Нүүрний хөдөлгөөн
- Ерөнхий төрх байдал

Анхаарах зүйлс:

- Идэвхтэй сонсох, анхаарал хандуулах, тодруулан асуух зэргээр санаа тавьж буйгаа ойлгуулах,

- Асуулт ба хариулт: Нээлттэй болон хаалттай асуултуудыг тохируулан ашиглах, тодруулах асуулт асуух хэрэгтэй.

- Бага ярьж илүү их сонсох, ярьж буй ярианд дэмжлэг үзүүлэх, яриаг таслахгүй байх.

Давуу талд тулгуурлан үйлчилгээ хүргэх: Энэ нь хоригдлыг чадваржуулах замаар түүний оролцоог дэмжиж асуудлыг шийдвэрлэхэд ашигладаг хандлага юм. ЛГБТИ хоригдолд ямар ч хүндрэл бэрхшээл тулгарсан бай тэрээр өөрийн өвөрмөц онцлог шинж, давуу тал бүхий хувь хүн гэдгийг ойлгож мэдэх хэрэгтэй. Хоригдлын давуу болон сул талуудыг тодорхойлж, давуу талд тулгуурлан асуудлыг шийдвэрлэдэг. Хоригдлын

зан төлөв, ур чадвар, дэмжлэгийн систем, нөөц боломжийн давуу талуудыг дараах асуултуудаар илрүүлж болно. Үүнд:

Хувь хүний зан төлөв:

- Өөрийн асуудлаа шийдвэрлэх хүсэл эрмэлзэлтэй байна уу?
- Мэдээлэл авахад нээлттэй хандаж байна уу?
- Өөдрөг үзэлтэй байна уу?
- Тавьсан зорилгоо биелүүлэхээр тууштай хичээж, зүтгэж байна уу?
- Гол асуудалд анхаарлаа хандуулж байна уу?
- Өөр орчин нөхцөлд дасан, хурдан зохицох чадвартай байна уу?
- Өөртөө итгэлтэй байдал, өөрийн үнэлэмж хэр байна вэ?

Ур чадвар:

- Боловсролын түвшин ямар вэ?
- Маш сайн хийж чаддаг ямар зүйлс байна вэ?
- Ямар төрлийн авъяастай байна вэ?
- Ямар ажлыг илүү сайн хийж сурсан байна вэ?
- Олон нийтийн дунд чөлөөтэй ярилцах чадвартай байна уу?
- Шинэ зүйлийг хэрхэн сонирхож хүлээж авдаг вэ?

Дэмжлэгийн систем:

- Хоригдлын бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг гэр бүлийн гишүүд болон найз нөхөд ойлгож, дэмжиж байна уу?

- Хоригдол ЛГБТИ олон нийтэд харьяалагддаг өөр найзууд байна уу?
- Хоригдол ЛГБТИ олон нийтийн эрхийн талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын талаар мэддэг, үйлчилгээ авч байсан, үйл ажиллагаанд оролцож байсан туршлага байна уу?

- Бусад хоригдлуудын ЛГБТИ талаарх ойлголт хэр байна вэ?

Нөөц боломж:

- Хоригдолд эдийн засгийн нөөц боломж байна уу?
- Өөрт буй боломжийг олж харж, ашиглаж чадаж байна уу?
- Нийгмийн үйлчилгээний байгууллагаас үйлчилгээ авч байсан уу?



Дээрх асуултуудад “Тийм” гэсэн хариултуудыг өгч байвал хоригдолд давуу талууд байна гэж үзнэ.

ЛГБТИ хоригдолтой хамтран давуу болон сул талуудаа тодорхойлсны дараа түүнд тулгарсан асуудлуудыг тэд хянаж, түүнд хариу өгөх, даван

туулах хүч бий гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Мөн одоо байгаа нөхцөл байдал цаашид хэрхэн өөрчлөгдөх боломжтой байгааг тайлбарлах хэрэгтэй.

**Үйлчилгээг үнэлэх, төгсгөх үе шат:**

Нийгмийн ажилтан үйлчилгээндээ явцын болон эцсийн үнэлгээг хийх хэрэгтэй” энэ талаар 1996 онд батлагдсан “Нийгмийн ажлын олон улсын ёс зүйн код”-д тодорхой тусгасан байдаг. ЛГБТИ хоригдолд гарсан өөрчлөлтийг үнэлэхэд дараах элементүүдийг анхаарах нь чухал.

Баталгаажсан байдал	Найдвартай байдал	Энгийн хэрэгтээтэй байх	Мэдрэмжтэй байх	Өөрчлөлтөнд идэвхгүй хэсгийг харгалзан үзэх
				
Хэрэгжих үйл явцыг хэрхэн таамаглаж, авч үзэж байгаа болох	Ижил нөхцөлд хэрэгжилтийг дахин давтан хийсэн тохиолдолд үр дүн ижил байх	Мэргэжлийн бус хүмүүст ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, тодорхой үр өгөөжтэй байх	Өчүүхэн төдий өөрчлөлт, ялгаатай байдлыг хэмжилтэнд авч үзэх	Ямар нэгэн өөрчлөлт харагдахгүй байгаа бол бусад талуудын ягтааг олж харах

Нийгмийн ажлын практикийн үйл явцын бүх үр дүнг үнэлж болох бөгөөд практикийн бүх үе шатанд тасралтгүй үнэлгээ, хяналт хийж байх үүргийг нийгмийн ажилтнууд хүлээдэг. Хоригдолд үйлчилгээ үзүүлэх үйл явц нь эцсийн үнэлгээ хийх, үйлчилгээг дуусгавар болгосноор төгсдөг.

**Дүгнэлт**

ЛГБТИ хоригдолтой ажиллахад бэлгийн чиг баримжааны талаарх ойлголт, бусад хүмүүсээс ирэх сөрөг үзэл хандлагууд, ЛГБТИ хоригдлын онцлог хэм хэмжээ, хэрэгцээний талаарх мэдлэг, эрүүл мэнд, сэтгэл зүй, харилцаанд тулгарах асуудлууд зэрэг олон талын үндсэн ойлголт мэдлэг, ур чадвартай байхыг хорих байгууллын нийгмийн ажилтнаас шаарддаг.

ЛГБТИ хоригдолтой ажиллах хамгийн сайн практик бол ЛГБТИ хоригдлын талаарх хэвшмэл буруу ойлготоос ангид аюулгүй, оролцоог хангасан, үйлчилгээний орчин бүрдүүлэх, тулгарч болох эрүүл мэнд, сэтгэл зүй, харилцааны эрсдэлийг тодорхойлох, тэдний өдөр тутмын амьдралд тохиолдож болох стресс, харилцааны зөрчлүүд, нийгмийн хүчин

зүйлүүдийг тодорхойлж хоригдолд туслах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх нь зайлшгүй юм.

Мөн хорих байгууллагын нийгмийн ажилтан нарт ЛГБТИ хоригдолтой ажиллах нийгмийн ажлын арга зүйг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах шаардлагатай байна.